

**“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл.**

№ 01

2020 оны 04 сарын 29-ны өдөр

Дархан сум

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019.04.29-ны өдрийн 14⁰⁰ цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 146025 ширхэг саналын эрхтэй 3 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 89.4 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар М.Цолмонг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох: 1. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан
3. Ногдол ашиг олгох тухай
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай зэрэг асуудлуудыг танилцуулж, дотоод журмыг баталлаа.

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Чулуун нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Би компанийн гүйцэтгэх захирлын хувьд хэдэн зүйл танилцуулъя. Өнгөрсөн жилийн хувьд яагаад огцом ашиг буурсан гэхлээр дээврийн ажилтай холбоотой маш том хөрөнгө оруулалт хийсэн. Түрээслэгчидээс дээврийн асуудлаар байнга санал гомдол ирдэг, хуучин дээвэр нь оросын мембрамаар хийсэн байдаг. 2018, 2019 онд “Ондилт” ХХК гээд дээврийн компаниар гүйцэтгүүлсэн. Бид энэ компанитай зөвшилцөж сар бүрийн хуваариар тохирч тооцоог одоог хүртэл төлж байгаа. Ногдол ашгийн өглөг өгөгдөөгүй байгаа учир нь дээврийн үйл ажиллагаатай бусад зардалд төлж байгаатайгаар хойшилсон харагдаж байгаа. Энэ жил мэргэжлийн хяналтын шаардлагын дагуу манайх хөргүүрийн байрыг засаж сайжруулах ажилтай байгаа. Одоо гадна талбайн мах зардаг лангуу тавиурыг шинэчилж сайжруулж засаж байгаа. 100% иж бүрдлээр нь 60 хөргүүр махны зааланд оруулахаар төлөвлөөд байж байна. Хөргүүрээ түрээслэгчид өөрсдөө авна, өөрийн хөрөнгө болохоор арчлаад хамгаалаад явна гэж бодож байгаа. Засварыг наадмаар 20 хоногт янзалж 8-р сар гэхэд дуусгахаар төлөвлөж байна.

Хурлын дарга: Гүйцэтгэх захирал танилцуулга хийж дууслаа. Өөр санал хэлэх хувьцаа эзэмшигч байвал тайлангуудтай холбоотой саналаа хэлж болно.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Ерөнхий нягтланд өөр нэмэж хэлэх зүйл байна уу? Байхгүй.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр санал гараагүй тул дараагийн асуудлыг танилцуулъя. Үүнд: ТУЗ нь хуралдаж ногдол ашиг олгох шийдвэр гаргасан. Үүний дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ, тараах хугацааг хэлэлцэж шийдвэр гаргана. Ингээд гүйцэтгэх захирал М.Оюун ногдол ашиг олгох эсэх талаар саналаа танилцуулна.

Хувьцаа эзэмшигч: Гүйцэтгэх захирал М.Оюун: Уул нь журмаараа 19 сая төгрөг хувиарлах ёстой. Одоо хуримтлагдсан ашигаас хувиарлаад нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 500 төгрөгөөр тогтоох уу? Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Саналыг дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Саруул: Дэмжиж байна.

Хурлын дарга: Миний хувьд дэмжиж байна. Өөр санал байхгүй бол хурлын тооллогын комиссийг ажилд оруулъя. Ингээд хурлаар хэлэлцэж буй

асуудлуудаар санал хураалт явуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал хураалтын хуудсыг тарааж санал хураалтыг явууллаа. Тооллогын комисс санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, хурлаас дараах тогтоол гаргахаар болов. Үүнд:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайлан, Санхүүгийн тайланг “ хангалттай ” дүнтэйгээр батлах тухай.
2. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 500 төгрөг олгохоор батлах тухай.
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгосон тухай.

Хурлын дарга хурлаас гарсан тогтоолуудыг танилцуулав.

Хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд ажлын өндөр амжилт хүсэн хурал өндөрлөж 16 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
/ Э.Жавхлантөгс /